

**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ
ВИЗИЙН ШААРДЛАГААС ХАРИЛЦАН ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар (цаашид “Хэлэлцэн тохирогч талууд” гэх),

Хоёр улсын хоорондын өнөөгийн найрамдалт харилцааг бэхжүүлэхийг эрмэлзэн,

Хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэдэд хоёр улсын хооронд зорчих, нутаг дэвсгэрт нь орох, гарахыг хөнгөвчлөх зорилгоор,

Дараахь зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

1 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч талуудын Гадаад хэргийн яамдаас олгосон хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч Хэлэлцэн тохирогч аль нэг талын иргэд нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт олон улсын шинжтэй хилийн боомтоор визгүй зорчих, дамжин өнгөрөх эрхтэй.

2. Хэлэлцэн тохирогч талуудын Гадаад хэргийн яамдаас олгосон хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч Хэлэлцэн тохирогч аль нэг талын иргэд нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт 2 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хил нэвтэрсэн өдрөөс эхлэн 180 (нэг зуун наяд) хоногийн хугацаанд 90 (ес) хүртэл хоногоос хэтрэхгүй хугацаагаар визгүй байх эрхтэй.

2 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт орших дипломат болон консулын төлөөлөгчийн газар, эсхүл олон улсын байгууллагад томилогдон ажиллах хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч Хэлэлцэн тохирогч аль нэг талын иргэд нь томилолтынхоо хугацаанд тухайн талын нутаг дэвсгэрт визгүйгээр зорчиж, оршин сууж болно.

2. Дээрх эрх нь 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүмүүстэй хамт амьдрах, 1 дүгээр зүйлд заасан паспорттай гэр бүлийн гишүүд (эхнэр, нөхөр болон хүүхэд)-д үйлчилнэ.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт дурдсан хүмүүсийн талаар Хэлэлцэн тохирогч нэг талын Гадаад хэргийн яам тэдгээрийг томилон ажиллуулахаас өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө талын дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.

3 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч аль нэг талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын хилийг нэвтрэх үедээ

болон нутаг дэвсгэрт нь байх хугацаандаа тухайн улсын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг тал Хэлэлцэн тохирогч нөгөө талын иргэнийг өөрийн нутаг дэвсгэрт байлгахыг хүсэхгүй тохиолдолд түүнийг өөрийн улсын хилээр нэвтрүүлэхээс татгалзах, өөрийн нутаг дэвсгэртээ байлгах хугацааг богиносгох эрхтэй.

4 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт дипломат болон албан паспортоо гэсэн тохиолдолд зохих арга хэмжээ авах нөхцөлийг хангах зорилгоор энэ тухайгаа хүлээн авагч улсын холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Холбогдох дипломат болон консулын төлөөлөгчийн газар өөрийн иргэнд түүнийг улсын хилээр нэвтрэх бололцоог олгох үүднээс зорчих шинэ баримт бичиг олгох бөгөөд энэ талаар хүлээн авагч улсын холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

5 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг тал нь улсынхаа аюулгүй байдлыг хангах, нийтийн дэг журам сахиулах, эсхүл нийтийн эрүүл мэндийг хамгаалах шалтгааны улмаас энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр зогсоож болно. Хэлэлцээрийн үйлчлэлийг түр зогсоосон тухай, эсхүл үйлчлэлийг түр зогсоосон шийдвэрийг хүчингүй болгосон тухайг шийдвэрийг Хэлэлцэн тохирогч нөгөө талдаа тухайн шийдвэр хүчинтэй болохоос 7 (долоо) хоногийн өмнө дипломат шугамаар мэдэгдэнэ.

6 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос 30 (гуч) хоногийн өмнө Хэлэлцэн тохирогч талууд өөрсдийн ашиглаж буй хүчин төгөлдөр дипломат болон албан паспортын загваруудыг тухайн баримт бичгүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийн хамт дипломат шугамаар харилцан солилцоно.

2. Шинэ баримт бичиг нэвтрүүлэх, эсхүл хэрэглэж буй дипломат болон албан паспортод өөрчлөлт оруулсан тохиолдолд Хэлэлцэн тохирогч талууд шинэ, эсхүл өөрчлөлт орсон баримт бичгийн загваруудыг тухайн баримт бичгүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийн хамт тэдгээрийг хэрэглэж эхлэхээс 30 (гуч) хоногийн өмнө дипломат шугамаар харилцан солилцоно.

7 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг дипломат шугамаар найрсгаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болгоход тавигддаг дотоодын шаардлагыг хангасан тухайгаа Хэлэлцэн тохирогч талууд харилцан мэдэгдсэн сүүлчийн ноот бичгийг хүлээн авсан өдрөөс хойш 90 (ер) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээрт харилцан зөвшөөрсний үндсэн дээр дипломат шугамаар бичгээр харилцан мэдэгдэх замаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

3. Энэхүү хэлэлцээрийг хугацаагүй байгуулав. Хэлэлцэн тохирогч аль нэг тал дипломат шугамаар бичгээр мэдэгдэх замаар энэхүү хэлэлцээрийг хэдийд ч цуцалж болно. Энэ тохиолдолд энэхүү хэлэлцээр нь тухайн мэдэгдлийг Хэлэлцэн тохирогч нөгөө тал хүлээн авсан өдрөөс хойш 90 (ер) хоногийн дараа хүчингүй болно.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТОЛЖ, өөр өөрийн Засгийн газраас зохих ёсоор эрх олгогдсоны үндсэн дээр энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 2011 оны 6 дугаар сарын 29-ний өдөр монгол, польш, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтлана.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**